



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 25 өдөр

Дугаар АЖ29

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29-р зүйлийн 29.1.6."г", 29.2, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9-р зүйлийн 3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит XI дүгээр хуралдааны 03 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Эмэгтэйчүүдийн холбооноос зохион байгуулж буй "Алунгоо - 2019" оны шилдэг эмэгтэй шалгаруулах ёслол хүндэтгэлийн арга хэмжээний зардалд 1500000 (нэг сая таван зуун мянган) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг аймгийн "Засаг дарга" дансны Хүүхэд хамгаалал, өрхийн хөгжлийг дэмжих нэрлэсэн жилийн хүрээнд зохион байгуулагдах арга хэмжээний зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төсвийн ерөнхий нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Нармандах)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х. Ган-Очир)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД